

НАНГИАДЫН УРАН ЗОХИОЛЫН МОНГОЛ ОРЧУУЛГЫН УЛАМЖЛАЛ ЗАРЧМЫН ТУХАЙД

М.ЧИМЭДЦЭЭ*

Монголын уран зохиолын далай их өв сангийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь орчуулгын уран зохиол билээ. Тэрхүү орчуулгын өв сангийн олтгойлж үл болох нэг чухал хэсэг нь нангиадын уран зохиолын монгол орчуулга юм.

Хятад орон нэн эртний түүх соёлтой, утга соёлын яндашгүй баян өв сантай, тэрхүү сан хөмрөг нь олон мянганы уламжлалтай, үлэмж баян тансаг бөлгөө.

Монголын номч мэргэн, эрдэм төгс олон дуун хөрвүүлэгч гүүш эрт дээр цагаас эдүгээ биднийг хүртэл үеийн үед уламжлан буухиалж, нангиадын утга зохиолын алдарт бүтээлүүдээс шилж сонгон, шигшиж сорчилон, тансаг сайхан монгол хэл найруулгаар дуун хөрвүүлэн орчуулж иржээ.

Хятадаас орчуулсан уран зохиолын зүйл хэдэн зууд хүрнэ гэж академич Б.Ринчен нэгэнтээ дурджээ. Энэ тоо эдүгээ жилээс жилд үржин олширсоор буй нь лавтай.

Монголчуудын олон зууны турш хийж ирсэн, эдүгээ ч хийсээр байгаа нангиадын уран зохиолын монгол орчуулгын уламжлал арга зарчим, түүнээс үүдэн бүрэлдсэн туршлага хийгээд уламжлал шинэчлэлийн залгамж холбоог задлан шинжилж мөшгин судлах нь нэн чухал юм.

Тиймийн учир энэхүү илтгэлд нангиадын уран зохиолын монгол орчуулгаар илэрч, боловсрон хөгжиж ирсэн орчуулгын зарим уламжлал, зарчмын тухай цухас өгүүлэхийг зорьсон болно.

Күнзийн суртлын сонгодог судар - “Ачлалт ном” (Тахимдуу бичиг)-ыг НОТ-ын 480 онд орчуулж байсан тухай түүхэн мэдээ байдаг. Сяньби нарын түүхийг судалсан доктор Г.Сүхбаатар агсан “Энэ үед “Ачлалт ном”-ыг орчуулан ерөнхийдөө унших бичиг болгон хэрэглэж байжээ. “Ачлалт ном”-

ын энэ орчуулга бол монгол хэлний анхны орчуулга гэж үзэж болох байх” гэж онцолсон байна. Харин энэ орчуулга бидний үед уламжилж ирсэнгүй.

Хувилай хааны ордны буурч, их гүүш Бултөмөр “Ачлалт ном”-ыг 1307 онд монголчлон дуун хөрвүүлсэн нь харин бидний үед уламжлан ирсэн юм. Бултөмөрийн орчуулгыг бүхэлд нь нарийвчлан үзвэл, уг эхийн утга санааг яруу тодорхой буулгахын тулд үг нэмж хасаж болдог чөлөөт орчуулгын зарчмыг чанд баримтлан дуун хөрвүүлдэг, эх хэл, хятад хэл аль алинд нь нэвтэрхий, тухайн цагтаа уран сайхны орчуулгад төгс боловсорсон бичиг номын билиг оюунт гүүш байсан нь тодорхой харагдана.

“Тахимдуу бичиг”-ийн орчуулгыг шинжин үзвэл, шинэ үг хэллэг нэмэн утгыг өргөн дэлгэр болгох, хоршоо холбоо үг хэрэглэн сэтгэл хөдөлгөх чадлы нь нэмэгдүүлэх, ерөнхий утгыг тодорхойд шилжүүлэн “мэдэхүйе хялбар” болгон орчуулсан жишээ олон байна. Тухайлбал:

Хятад эх: 富贵不离其身, 然后能保其社稷

Баяжих ноёлох хоёрыг биеэс эс салган чадах аваас сая төр улсаа батжуулан, албат иргэнээ засан тохинуулж чадна гэсэн эх зохиолын санааг Бултөмөр “Баяжих ноёлох хоёроор биес эцэгэн эс эл ангижруулваас тэндэцэ сая өтэгэн эх-дэ тарианы онгод-та тахилаа гүйцээн чадаад иргэн органыг найруулан чадаюу... [1. 8] хэмээн орчуулжээ.

Хятад хэлний 社 нь “газрын сахиусан”, 稷 нь “тарианы сахиусан” хэмээсэн үг бөгөөд газар шороо үгүй бөгөөс хүн оршиж эс чадах, амуу тариа үгүй бөгөөс амьдарч эс чадах тул энэ хоёр үгээр “Эх орон” гэсэн утгыг төлөөлүүлэн нэрлэдэг ёс байдаг. Хожмын

* М.Чимэдцээ. МУИС-ийн ГХСС-ийн багш, доктор (Ph.D)

орчуулагчид энэ үгийг “төр”, “газрын тэнгэр” гэх зэргээр орчуулсан бол Бултөмөр гүүш нангиад эхийн энэ санааг “Өтэгэн эх” хэмээн яруу зохист монгол хэллэгээр оноон орчуулжээ.

Энэ нь XIV зууны үеийн уран сайхны орчуулгын практикт тодорхой илэрч байсан, шууд үгчлэхээс зайлсхийн, далд гүн утгыг гаргахдаа уг зүйл чухам юуны нэр болохыг давхар тодотгон, монгол ахуйд идээшүүлэн, яруу дүрслэлийн амт оруулан дуун хөрвүүлдэг байсан уран сайхны орчуулгын уламжлал, зарчмын нэг жишээ юм. 1740-өөд онд туурвисан “Мэргэд гарахын орон”-д орчуулгын ийм арга зарчмыг бас томъёолсон бөгөөд тэрхүү арга зарчим аль XIV зууны үед Бултөмөрийн нангиад хэлнээс хийсэн болон бусад уран сайхны орчуулгаар дамжин боловсорч ирсэн байна.

“Этүгэн эх” хэмээх энэ үг “Монголын нууц товчоо”-нд бас буй. “Этүгэн эх агуу буй. Ус мөрөн олон буй” [2.137] “Хөрст этүгэн хөрвөж бүлгээ. Гүрэн улс тулалдан бүлгээ.” [2.135] гэхчлэн өгүүлсэн байдаг. Өөр нэгэн жишээ авъя:

Хятад эх: 三才章第七

Үгчлэн орчуулвал: Гурван эрдмийн долоодугаар бөлөг

Бултөмөрийн орчуулга: Тэнгэр газар хүмүүн гурван ёсныг өгүүлэх долдугаар бөлөг. [1. 19]

Хожмын орчуулгуудад “гурван эрдэм” гэж шууд үгчлэн орчуулжээ. Бултөмөр уг бөлөгт тэнгэрийн ёс, газрын ёс, хүмүүний ёсыг сурган өгүүлсэн хам сэдвийн агуулгын хүрээнд нь гүнзгийрүүлэн сэтгэж, үг үсэгт баригдалгүйгээр, утга санааг нь тэлж дэлгэрүүлэн, “тэнгэр, газар, хүмүүний гурван ёсон” гэсэн уг эхийн хураангуйлсан цаад санааг шинэ үг илэрхийллээр нөхөн гаргаж дуун хөрвүүлсэн нь орчуулагчийн ур ухаан, эрдэм чадварын илрэл, хятадын уран зохиолын монгол орчуулгын нэгэн чухал уламжлал болно.

Хятад эх: 子曰: 天地之性, 人为贵

Үгчлэн орчуулвал: Күнз өгүүлрүүн: Тэнгэр газрын чанарт хүмүүн эрхэм болой.

Бултөмөрийн орчуулга: Күнфүзы өгүүлрүүн: Тэнгэр газрын зуур хамаг амьтны дотор хүмүүнээс дээд үгүй. [1. 31]

Хожмын орчуулгууд хятад эхийг ягштал мөрдөн “тэнгэр газрын чанар” гэж орчуулсан

бол Бултөмөр эх зохиолын үг үсгийн утгыг дэлгэрүүлэн, уран сайхны бүтээлч баяжуулалт хийж, “тэнгэр газрын зуур”, “хамаг амьтны дотор” гэхчлэн үг нэмэн тодотгож, “хүмүүнээс дээд нь үгүй” гэж хүч нэмэгдүүлэн, уг эхийн утга санааг бүрнээ илэрхийлэн, шүлэг найраг мэт яруу сайхнаар найруулан орчуулжээ. Энэ бол дуун хөрвүүлэгчийн цоо шинэ үүтгэл санаа юм.

Бултөмөрийн орчуулгад энэ мэтчлэн эх зохиолын үг үсгийн утга санааг гойд нарийн тунгаан ухаж, улмаар өргөтгөн дэлгэрүүлж, монгол хэлний тохирох үг хэллэгийг сайтар онолдуулан, яруу сайхнаар найруулан, утга төгөлдөр дуун хөрвүүлсэн жишээ олон байна.

Академич Б.Ринчен бичихдээ: “Нангиадын эртний бичиг утгыг нэвтэрхий мэдэх хүн монгол бичгийн хэлэнд бас сайн бөгөөд нангиад монгол үгийн дүйцлийг монгол хэлний эртнээс нааш олон зуун жилийн турш маш нарийн боловсруулсан уламжлалтайн учир бас нэвтэрхий мэддэг нь зайлшгүй болж ирдэг учир, тийм мэдэлгэтэн дуун хөрвүүлэгч нар маш сайхан орчуулдаг байлаа” [3.153] гэж тэмдэглэсэн байдаг.

Монгол ахуй амьдрал, зан заншлын өвөрмөц онцлогт тохируулан таацуулж зохиолын уг эхийг өөрчлөн найруулж, монгол ахуйд идээшүүлэн орчуулдаг чиглэл, арга зарчим XVIII зууны үеийн монгол орчуулгын бүтээлд уламжилж ирсэн байна. Жишээ болгон, 1721 онд “Их Чин улсын шулуун шарын тэргүүн жинхэнэ түшмэл бөгөөд туслагч жанжин Арана”-гийн орчуулсан “Тансан ламын баруун этгээдэд зорчсон түүх” зохиолын нэгэн хэсгийг авч үзвэл:

Хятад эх: ...就做个齐天大圣, 有何不何? 猴王闻说, 喜欢不胜, 连道几个“好! 好! 好!” 教四健将: “就替我快置个旌旗, 旗上写齐天大圣四大字, 立竿张挂。自此以后, 只称我为齐天大圣, 不许再称大王。 [4. 23]

Үгчилсэн орчуулга: ...Тэнгэр лүгээ сацуу их богд хэмээвээс юун үл болох буй? Бичний хаан үүнийг сонсоод ихэд баясан, “зөв, зөв, зөв” хэмээн хэдэнтээ өгүүлээд, дөрвөн баатартаа: “Надад нэгэн туг хиур босгож, дээр нь тэнгэр лүгээ сацуу их богд гэсэн дөрвөн үсэг томоор бичиж, өөд нь өлгөж зүү, үүнээс хойш намайг тэнгэр лүгээ сацуу их богд хэмээн дуудагтун, их хаан гэж

сонирхолтой зүйл бол бөлгийн гарчгийн санааг яруу сайхнаар шүлэглэн, уг бөлгийн эхэнд нь оруулдаг уламжлал юм.

Зарим нэг жишээ дурдвал:

Хятад эх:

第二回 悟彻菩提真妙理 断魔归本合元神 [4. 7]

Үгчлэн орчуулсан нь: Хоёрдугаар бөлөг. Ү Күн бодьсадад төгс нэвтэрч, арга ухаанд боловсроод, шуламсыг дарж, уг биеийг эргүүлэн хувилгаан дүрийг хураасан нь:

Аранагийн орчуулга:

”Эрх хүчит тэр бичний хаан

Дээд сайн багшийг эрж олоод

Эе-бээр хаан болон суугаад

Этгээд шуламсыг дарж

Эрдмээ илтгэн үзүүлсэн хоёрдугаар бөлөг”[5.12]

Эндээс үзвэл, орчуулагч тухайн бөлгийн гарчгийг хатуу үгчлэн орчуулсангүй, харин уг бөлөгт өгүүлэх үйл явдлын нийт хүрээнд утга санааг нь хураангуйлан, хятад эхэд байхгүй шинэ үг хэллэг нэмэн монгол шүлгийн журмаар толгой холбон шүлэглэж, уран сайхнаар зангидан өгүүлсэн байна. Энэ нь монгол ахуйд илүү ойртуулан, монгол уншигчдад сонирхолтой болгохын үүднээс хийсэн шинэ үүтгэл санаа юм.

Орчуулагч бөлөг бүрийн төгсгөлд уг бөлгийн товч утгыг уран яруу шүлэглэн зангидан өгүүлдэг уламжлал арга нангиадын уран зохиолын орчуулгын бүтээлд олон буй. Тухайлбал, “Эрт эдүүгээхийн гайхамшигт сайхан үзэгдэл хэмээх судар”-ын бөлөг бүрийн төгсгөлд уг бөлгийн товч утгыг тийнхүү шүлэглэн өгүүлсэн байдаг. Уг зохиолын “Шяны мэдэгч хоёр ноён хоорондоо өнчин хүүхнийг хамтатгабай ” хэмээх дэд бөлгийн төгсгөлд “Энэ нэгэн бөлөг дор өгүүлсэн үгийг ухамсарбаас,

Үр хөвгүүн чухаг хүмүүн үзэсгэлэн

өнгийг эрхэмлэх хэрэг үгүй ажаам

Өнчрөн хагацсаныг тэтгэж үнэнээр

буяныг үйлдэлтэй ажаам

Өнгө жаргаланыг эрхилвээс өөрийн

бие хохирогдол болох ажаам

Өнчин бядгууг тэтгэж асарваас

үнэхээр буян цаглашгүй ажаам [6. 14]

хэмээн шүлэглэж уг үлгэрийн гол утгыг хураангуйлан өгүүлсэн байдаг билээ.

“Шүй ху жуань”(水浒传) хэмээх хятадын алдарт зохиолын нэрийг монголоор “Усан

булгамалын бичиг”, “Голын тохой”, “Мөрний хариг” гэх зэргээр янз бүрээр нэрлэсэн байдаг. Гэвч энэ зохиол “Сүн улсын хүйтэн уулын бичиг” хэмээх нэрээр алдаршсан юм. Зарим судлаачид “Хүйтэн уулын бичиг” гэдэг нэр нь ташаа орчуулга гэж үздэг. Зохиолын баатруудын оршин байсан Ляншань (梁山) уулын эргэн тойрны усыг Шүй ху гэдэг байснаас үүдэн зохиолыг “Шүй ху жуань” буюу “Шүйхугийн үлгэр” хэмээн нэрлэсэн бол, монгол орчуулагчид тэрхүү ляншань буюу лян хэмээх уулын нэрийн дуудлагаар “Хүйтэн уулын бичиг” гэж орчуулсан байна. Угтаа лян гэсэн ханз үсэгний дуудлага нь “хүйтэн” гэх утгатай өөр ханз үсэгний дуудлагатай таарах боловч дүрс хийгээд утга нь өөр өөр учир тийнхүү оносон бус гэж үздэг байна.

Монголын эрдэмт гүүш нар уг номын нэрийг тийнхүү өөрөөр орчуулсан нь лав мэдэхгүйдээ буюу санамсаргүй гарсан мадаг яавч биш бол уу. Зохиолд эргэн тойрон усаар хүрээлэгдсэн Ляншань буюу Ляншань уулнаа нэг зуун найман зоригт эрс “тэнгэрийн хувь зохиолоор барилдаж, төрсөн нутаг ус өөр боловч, нэгэн эхийн хөвгүүд, элэг зүрхний зузаан янаг ах дүү болж, жаргах зовохыг хамт эдлэн” буй гайхам үйл явдлыг уран яруу дүрслэн өгүүлсэн зохиолыг нэвт гарч буй агуулгын хүрээнд нь авч үзэн, мөнхүү монгол орчуулгын уламжлалыг даган монгол ахуйд идээшүүлэн, усанд бус ууланд болж буй хэрэг явдал тул уулын нэрний ижил дуудлагыг нь зээлдэн зориуд “хүйтэн уулын” хэмээн орчуулсан болж таарч байна. Бас уг эх зохиолын нэрнээ байхгүй ч гэсэн зохиолын үйл явдал Сүн улсын үед болж байгаа учраас уншигчдад илүү ойлгомжтой, сонирхолтой болгохын үүднээс “Сүн улсын” гэж эл зохиолын хам утгын өрнөлөөс ургуулан тийнхүү нэрийджээ.

Зохиолын нэвт гарч буй хам сэдэв, хам утгыг түшин, өөр нэр оноон орчуулдаг энэ уламжлал зарчим эдүгээ уран сайхны орчуулгын нэгэн бүтээлч эрэлхийлэл, оновчтой арга болон хөгжиж байна.

Эртний хятадын алдарт “Таван ном дөрвөн бичиг”-ийн доторх Таван ном”-ын нэг нь “Шүлэглэлт ном” (诗经) юм. “Шүлэглэлт ном”-ын дотор багтсан шүлэг найраг, яруу дуулал нь цаг хугацааны хувьд НОТ-ын өмнөх XI-VI зууны үед хамаарагдана. Энэ утгаараа

“Шүлэглэлт ном” бол эртний нангиад орны бүхэл бүтэн үеийн дүр төрхийг тусгасан өвөрмөц нэгэн толь билээ.

Их сэтгэгч Күнз эш сургаалдаа: “Шүлэглэлт ном”-ын гурван зуун шүлгийг сурч мэдсэний хойно засгийн хэргийг захируулахуйд эс чадах хийгээд дөрвөн зүгт зарлигаар зарахуйд эзэн мэдэж эс чадваас, эрдэм ном сурсан нь их боловч эрхбиш хэрэглэх газар үгүй буюу” [8.90] хэмээн эрх хэргэмтэнд сануулсан байдаг.

“Шүлэглэлт ном”-ыг монгол хэлнээ дуун хөрвүүлэн орчуулж ирсэн билээ. Зэрэг хэргэмээ алдаж, мөхөж доройтсон нэгэн эрхтэн урд өмнө сайн сайхан явснаа гашуудан дурсаж буй гунил дууг хэрхэн монголчлон орчуулсныг шинживээс нангиадын шүлэг найргийн уран сайхны орчуулгын уламжлал зарчмын зарим зүйлийг тодорхой харж болно.

Хятад эх:

权輿

於！我乎，夏屋渠渠，

今也每食无餘。

于嗟乎！不承权輿。

於！我乎，每食四簋，

今也每食不饱。

于嗟乎！不承权輿。

[9.174]

Хятад эх шүлгийн журмыг аль болох эвдэлгүйгээр үгчлэн орчуулвал:

Анхандаа

Ай! Би чинь, Асар минь өндөр их байв,

Харин өнөө хоол унд ч үгүй хоосон.

Гаслантайя! Анх байсан бүгд алга

болов.

Ай! Би чинь, Амтат хоол аяга дүүрэн

байв,

Харин өнөө ходоод хонхолзон өлөн.

Гаслантайя! Анх байсан бүгд алга

болов.

Өвөрлөгч эрдэмтэн Дэлгэрсаны орчуулга:

Анхны дор (Чин газрын дуу)

Аяа хоохой! Ер нь би

Асар тагт дор сууж байсан бөлгөө,

Амуу будаа одоо нэгэнт тасарвай.

Ай халаг!

Анхны дор адилтгаваас өсөд зөрмүй.

Аяа хоохой! Ер нь би

Амтат идээнээр ширээ дүүрэн бөлгөө

Арга алдартал одоо гэдэс өлсмүй.

Ай халаг!

Анхны дор адилтгаваас өсөд зөрмүй.

[10.143]

Доктор, профессор

Ц.Базаррагчаагийн орчуулга:

Түшмэдийн гуниглал

(Чин нутгийн дуу)

Аяа! Би гэдэг

Асрын өндөрт аагиж явлаа.

Аяа! Гэтэл өнөөдрийн өдөр

Атгахан будаагүй өлөн.

Аяа! Хоохой!

Аагиж аахилж явсантай минь

Адилшаах юм огтхон ч алга даа.

Ээ-ээ! Хөөрхий!

Идээ будаанд бялуурч

Илийрч, бас халуурч явлаа.

Ээ-ээ! Тэгтэл өнөөдөр!

Идэх уухаар дутаж гуцаж

Өлбөрч, бас өрвөлзөж явна аа.

Ээ-ээ! Хоохой!

Илийрч бялуурч явсантай минь

Ижилсээх юм юу ч алга аа! [11. 41]

Юуны өмнө шүлгийн гарчгийг хэрхэн орчуулсныг үзвэл, Дэлгэрсаны орчуулганд эх зохиолын үг утгыг хатуу баримтлан, “Анхны дор” гэсэн бол, Ц.Базаррагчаа шүлгийн нэвтрэн гарах хам утгаас нь ургуулан, “Түшмэдийн гуниглал” гэж өөр шинэ нэр үүсгэн орчуулжээ. Ийнхүү нэвтрэн гарах утгы нь түшин чөлөөтэй зохиомжлон орчуулах ёсон монгол орчуулгын нэгэн чухал арга зарчим болох тухай бид дээр дурдсан билээ.

Тийнхүү орчуулахдаа “Ай”, “Ер нь би”, “Аяа хоохой”, “Ай халаг” гэх буюу “Аяа! Би гэдэг”, “Аяа хоохой!”, “Ээ-ээ! хөөрхий!”, “Ээ-ээ хоохой!” гэхчлэн яруу дуудал, яруу асуулт, яруу хандал зэргийг өргөн хэрэглэн сэтгэлийн уярал догдлол, гуниг шаналалыг хүчтэй илэрхийлж, тийнхүү уран дуудал, уран хандалыг чадмаг хэрэглэн орчуулснаар хятад шүлгийн журмыг төдий л эвдсэнгүй, харин санааг улам хурцлан, яруу сонсголонтой болжээ.

Хятад шүлэг найргийн нэг онцлог нь мөр шадын доторх үгийн (үсгийн) тоо хатуу тогтсон хэм хэмнэлтэй байдаг. Дэлгэрсаны орчуулгыг үзэхүл, уг эхийн энэ журмыг хатуу мөрдөн, толгой сүүл холбон орчуулжээ. Түүнчлэн хятад эхийн арван шадыг яг хэвээр нь хадгалан монголоор арван шад

болгон орчуулжээ. Энэ нь хятад орчуулгын “шударгуу үнэн”, “ойлгомжтой тод”, “яруу сайхан” гэсэн орчуулгын үндсэн зарчмыг баримтлан хөрвүүлснийг харуулж байна.

Ц.Базаррагчаагийн орчуулгыг үзэхүл эх шүлгийн үг үсэг, хэлбэр журамд төдий л хатуу баригдалгүй, шинэ үг илэрхийлэл, хоршоо холбоо үг нэмэн шүлгийн сэтгэл хөдөлгөх чадлы нь илтгэхийг илүүтэй анхаарсан нь ажиглагдана. Тухайлбал, “аагиж аахилж”, “илийрч халуурч”, “өлбөрч өрвөлзөж” гэхчлэн холбоо үг хэрэглэж, яруу дуудлыг шинээр нэмэн толгой холбож, мөрийн хэмжээг тэгшитгэсэн байна.

Академич Ц.Дамдинсүрэн “Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай” өгүүлэлдээ, “...Шүлгийг орчуулах гэгч үг утгыг орчуулах төдий биш, түүний найруулгын хэв журам ба уран хэл, сэтгэлийг хөдөлгөх чадлыг бүрнээ орчуулах хэрэгтэй.” хэмээн онцолсон билээ. Түүнчлэн шүлгийг монголчлохдоо монгол шүлгийн эн зэрэгцүүлэх ёсыг баримтлан, хоёр ба есдүгээр, гурав ба арван нэгдүгээр, зургаа ба арван тавдугаар, долоо ба арван зургаадугаар мөрүүдийг зэрэгцэн адилаар орчуулжээ.

Монгол шүлгийн мөр нь урт болвол уншихад нуршилтай болох мэт тул эрхбиш богино мөртэй шүлгээр орчуулахыг акад.Ц.Дамдинсүрэн ихэд чухалчилсан байдаг. Тэрбээр монгол ардын аман зохиолын дууны шүлэг ихэнхдээ гурван үгт шүлэг байдгийг бас дурдсан билээ.

Ц.Базаррагчаа дээрх шүлгийг монголчлохдоо хятад эхийн арван мөрийг арван зургаа болгон мөрийн тоог нэмж, харин мөр тус бүрийн үгийг гурваас дөрвөн үгэнд багтаан орчуулжээ.Тийнхүү мөр богино, шүлэг хөнгөн болж, ардын аман зохиолд илүү ойртон, унших сонсохуйд яруу сонсголонтой болсон байна.

Ингэж нэг мөр шадыг хоёр мөр болгож орчуулах нь монгол орчуулгын эртний уламжлалт арга зарчим юм.

XX зууны сүүлийн хагаст хятад хэлнээс монгол хэлнээ орчуулсан хятадын уран зохиолын зүйлийн дотор Тан улсын (618-906 он) яруу найргийн орчуулга чухал байрыг эзэлдэг. Монголын эрдэм билигт дуун хөрвүүлэгчид Тан улсын яруу найргаас тийнхүү зориуд сонгон орчуулдаг нь ер санамсаргүй хэрэг биш ажгуу. Учир юун

хэмээвээс Хятадын уран зохиолын түүхнээ Тан улсын үе онцгой чухал байрыг эзлэх агаад энэ үеийг “Хятадын яруу найргийн алтан үе” хэмээн нэрлэдэг билээ.

“Тэнгэрийн иргэн-Тэнгэрлэг найрагч “хэмээн нэрлэгддэг Ли Бай (701-762 он)-н тансаг сайхан шүлэг найргаас 35 шүлгийг нь сонгон, Монголын нэрт яруу найрагч Б.Явуухулан, нэрт яруу найрагч, орчуулагч Ч.Чимид нар орос хэлнээс монгол хэлнээ дуун хөрвүүлэн, 1960 онд “Шүлгүүд” хэмээх бэсрэг ном хэвлүүлсэн билээ.

Дорнын их найрагч Б.Явуухулангийн “... их найрагчийн уран бүтээлийг эх хэл дээр нь буюу ядаж нэг удаа орчуулагдсан хэл дээр уншвал улам ч амттай” хэмээсэн ерөөл хүслийг энэ зууны 80-90-ээд оны дундуур эрдэмтэн зохиолч, орчуулагч Ц.Базаррагчаа, эрдэмтэн зохиолч, орчуулагч Я.Ганбаатар нарын дуун хөрвүүлэгч гүйцэлдүүлэн, Ли Байн шүлэг найргаас монгол хэлнээ хятад эхээс нь орчуулсан билээ.

Ли Байн шүлгийн орчуулгын уран чадвар, яруу сайхныг сонирхохын үүднээс дэлхий дахинаа ихэд алдаршсан нэгэн дөрөвт шүлгийг манай нэрт дуун хөрвүүлэгчид монгол хэлнээ хэрхэн орчуулсныг сонирхон үзвэл:

Орос орчуулга нь:

Думы тихой ночью
У самой моей постели
Легла от луны дорожка.
А может быть, это иней?—
Я сам хорошо не знаю.
Я голову поднимаю---
Гляжу на луну в окошко,
Я голову опускаю
И родину вспоминаю.

Яруу найрагч Б.Явуухулан, Ч.Чимид нар орчуулсан нь:

Намуун шөнийн бодол
Орны минь дэргэд жим мөр шиг
Сарны туяа тусав.
Орой намрын хяруу ч юм уу
Ёстой бүү мэд.
Тэргүүнээ би дээш нь өргөж
Гэгээвчээр сарыг ширтлээ.
Тэгмэгцээ доош нь гудайлгаж
Эх нутгаа саналаа.[12.45]

Хятад эх нь:

静夜思
床前明月光,

疑是地上霜。
 举头望明月，
 低头思故乡。

**Эрдэмтэн зохиолч, орчуулагч
 Ц.Базаррагчаа хятад хэлнээс орчуулсан
 нь:**

Намрын шөнийн бодол

Орны минь өмнө унасан сарны гэрэл
 Орой намрын хяруу мэт цайлалзвай
 Толгой өлийн гэгээн сарыг ажиглаад
 Толгой гудайн эх нутгаан санагалзвай
 [13.11]

Б.Явуухулан, Ч.Чимид нар орос эхийг барин дам орчуулахдаа, “хятадаас орос, оросоос монгол хэлэнд дамжсаныг зүйрлэвэл, хятад торгыг усанд хоёр дахин дүрж гаргасантай төс нэгэн буй” хэмээн өөрсдийн орчуулгыг ихэд голон буйгаа тэмдэглэсэн нь буй. Нэрт дуун хөрвүүлэгч нар тийн орчуулахдаа, хэдийгээр орос эхэд баригдсан ч, уг шүлгийн яруу сайхныг бүрнээ илтгэхийн тулд шинэ үг илэрхийлэл нөхөн нэмэх зэргээр найруулан орчуулсан байдаг. Уг орос орчуулгад байхгүй “орой намрын” гэсэн жинхэнэ монгол ахуйн яруу хэллэг нэмсэн нь үүний нэг жишээ юм. Үүнийг уг шүлгийн сэтгэл хөдөлгөх чадлы нь гаргах, эх нутагаа санасан хүний сэтгэлийн хөнгөн гунигийг илүү тод илэрхийлэх, шүлгийн яруу сайхныг бүрнээ илтгэн, монгол уншигчийн сэтгэл зүйд улам ойртуулах зорилгоор хийсэн уран сайхны найруулгын нэг төгөлдөр жишээ гэж хэлж болох буйзаа. Шүлгийн хятад эхийг үзвээс “хяруу” гэж байхаас бус “орой намрын” гэсэн хэллэг байхгүй. Гэтэл хяруу орой намар л буудаг жамтай билээ.

Ц.Базаррагчаа уг шүлгийг хятад хэлнээс хөрвүүлэхдээ, хятад шүлгийн журмыг огт эвдэлгүйгээр, мөн дээр өгүүлсэн зүй тогтлыг гярхай ажиглан, монгол ахуйд ойртуулан, “Орой намрын хяруу” хэмээн орчуулсан нь монгол хүн уншиж, сэтгэл хөдлөн, таашаал авахад улам хүч нэмсэн яруу найруулга болж чаджээ. Эндээс монголын нэрт орчуулагчид аливаа уран сайхны орчуулгад учир шалтгааны зүй тогтол, уншигчийн сэтгэл зүйг илүүтэй анхаардаг нь ажиглагдаж байна. Энэ нь угтаа шүлгийн сэтгэл хөдөлгөх чадлы нь орчуулж буй хэрэг юм. Өөр нэгэн шүлгийн орчуулгыг авч үзье.

**Б.Явуухулан, Ч.Чимид нар орос
 хэлнээс орчуулсан нь:**

Лушань уулан дахь хүрхрээг харахад
 Алсын буурал униарын тэртээ
 Улбар туяа татав.
 Арсгар уулыг би ширтэж
 Урт хүрхрээг сонирхов.
 Үүлэрхэг өндрөөс буусан хүрхрээ
 Уулын хөвчийг зүсчээ.
 Үзтэл, тэнгэрийн зүйдэл дорогшоо
 Унасан юм шиг сунажээ. [12.19]

**Ц.Базаррагчаа хятад хэлнээс
 орчуулсан нь:**

Лу уулын хүрхрээг ажиглахуйяа
 Хүлс хадыг наран ээхүйеэ, манан
 суунаг татаж
 Хүрхрээн усан гурван мянган тохой
 өндрөөс
 Гол руу, шаагин шуугин, цэнхэртэн
 буухуй нь
 Газар руу, тэнгэрийн заадас тэр
 чигээрээ унах мэт ээ [13.11]

Эхний орчуулгад мөн орос орчуулгын шүлгийн журмыг баримтлан, найман шад болгон орчуулжээ. Уг шүлгийн эх зохиол нь тус бүр долоон ханз үсгээс бүтсэн дөрвөн шад шүлэг байна. Ц.Базаррагчаа орчуулахдаа тэрхүү хятад шүлгийн журмыг хэвээр хадгалан, зэрэгцүүлэн толгой холбон шүлэглэжээ.

Эхний орчуулгад “гурван мянган тохой” гэсэн хэллэгийг “урт” гэсэн нэг л үгээр орчуулжээ. Орос орчуулгыг үзвэл энэ үг бас алга байна. Магадгүй орос уншигч “тохой” гэсэн дорно дахины уртын хэмжээний ухагдахууныг ойлгоход бэрхтэй тул тийнхүү дөхөмчлөн орчуулсан бол уу. (“Хятад орос толь бичиг”-т: чи (кит.фут. около 0,33 м) гэж тайлбарласан байна.) Тэгвэл хоёрдахь орчуулгад уг хэллэгийг шууд утгаар нь “гурван мянган тохой өндөр” хэмээн буулгасан нь монгол ахуйд шууд буун, уншиж сонсоход илүү яруу сайхан найруулга болж чаджээ.

Дээр өгүүлсэн хоёр жишээг орчуулгын нэгэн уламжлал, онол зарчимтай холбон ойлгож болох юм. Доктор, профессор Л.Хүрэлбаатар утгачлах үгчлэх хоёрыг хэт туйлшруулах бус, “...чухамхүү “цаг үеийг нь олохын эрхээр” гэдэг орчуулгын гол онолын дагуу, дууг (үгийг) ямарчлан байсан ёсоор нь орчуулах зохистой газар дууг хатуу баримталж нэрэнд зүүх ба дууг заримдаа утгачлах зохистой газар утгыг хатуу барьж нэрэнд зүүхийн үүднээс, тухайн

орчуулгын бүтээлийн ямар агуулгатайгаас, хэнд юунд хандсан хэрэгцээ зориулалтаас шалтгаалан, харилцан их өөр өөр байж болохыг” [14.134] бүтээлдээ тэмдэглэсэн билээ. Энэ нь хэдийвээр судрын аман орчуулгын уламжлалд илүү хамааралтай боловч дээрх хоёр үг илэрхийлэлтэй холбон тайлбарлаж болох мэт. Орчуулагч “Гурван мянган тохой” гэснийг “өндөр”, “урт” гэхчлэн орчуулсангүй, монгол хүний сэтгэлд буух талыг нь бодолцон шууд үгчлэн орчуулсан нь “дууг ямарчлан байсан ёсоор нь орчуулах зохистой газар дууг хатуу баримтлан нэрэнд зүүсэн”, харин “хяруу” гэснийг монгол ахуйд илүү ойртуулан, санааг нь хурц тод, яруу сонсголонтой болгохын үүднээс “орой намрын хяруу” гэж шинэ үг үүсгэн орчуулсан нь “дууг заримдаа утгачлах зохистой газар утгыг хатуу барьж нэрэнд зүүсэн” жишээ гэж холбон ойлгож болох буйзаа.

Тиймээс ч энд өгүүлсэн жишээ бол орчуулгад ганц нэг үг хэллэг нэмэх, хасахтай холбоотой төдий асуудал биш, эцсийн бүлэгтээ монголын уран сайхны орчуулгын уламжлал, арга зарчим тасралтгүй хөгжин боловсорч, тэр нь шинэ нөхцөлд шинэ хэлбэрээр илрэн тодорч байдгийн нэг жишээ гэж үзвээс зохилтой.

Уламжлал нь ямагт шинэчлэлээр баяжин илэрч байдаг, шинэчлэл үгүй уламжлал гэж байж үл болох жамтай билээ. Тэрхүү шинэчлэл нь өмнөх үеийн уламжлалыг энгийн нэг давтах бус, шинэ сэтгэлгээ, шинэ жаяг зарчим, арга хэлбэрээр баяжиж байдаг ажээ. Хятадын сонгодог уран зохиолыг монголчлон орчуулж ирсэн үе үеийн дуун хөрвүүлэгч, гүүш нарын орчуулгын гайхамшигт бүтээл, түмэн алжаалт их хөдөлмөр зүтгэл, бүтээлч эрэлхийллээр тэтгэгдэн баяжиж, цогцлон бүрэлдэж ирсэн орчуулгын уламжлал зарчим, арга туршлага нь өнөөдөр нангиадын уран зохиолыг орчуулах явцад үүссэн аливаа тулгам төвөгтэй асуудлыг шийдвэрлэх зөв арга зам, орчуулгын уран чадварыг улам төгөлдөржүүлэх ухаан бодролыг орчуулагч нарт зааж нээж өгч байна. Нангиадын уран зохиолын монгол орчуулгын уламжлал, арга зарчим, уран чадварыг шинжлэн судлахын гол ач холбогдол үүнд оршиж байна.

НОМ ЗҮЙ

1. Тахимдуу бичиг. Юаны төрд орчуулагдсан бичгийг Боржигин Мандула сийрүүлэв. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 2005.
2. Монголын нууц товчоо. Сонгомол эх. Ерөнхий редактор академич Цэрэнсодном.Д. УБ., 2005.
3. Ринчен.Б “Марк Твенний минь махы нь идэж дээ”. (Орчуулгын тухай) Эмхэтгэн эрхэлж оршлыг бичсэн Аким.Г. УБ., 1991.
4. Ү Чэнь Энх. Тансан ламын баруун этгээдэд зорчсон түүх. 吴承恩 著。西游记 Чанша. 2004.
5. Ү Чэнь Энх. Тансан ламын баруун этгээдэд зорчсон түүх. I,II боть. Орчуулсан Арана. Монгол гар бичмэлийг кирилл бичигт буулгасан Хөвсгөл. С. Ариунцэцэг. Д. УБ., 1996.
6. Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл хэмээх судар. Дээд дэвтэр. Corpus Scriptorum Mongolorum Instituti Linguae Et Litterarum Comitetti Scientiarum Et Educationis Altea Reipublicae Populi Mongoli, Tomus XI. УБ., 1959.
7. Ши Най ань. Сүн улсын хүйтэн уулын бичиг. Монгол бичгээс кирилл бичигт буулгасан Хөвсгөл.С, П.Одсүрэн. УБ., 1997.
8. Шүүмжлэл өгүүлэл. Хятад хэлнээс орчуулсан Чимэдцээ.М. УБ., 2004.
9. Шүлэглэлт ном. 诗经. Тайюань. 2003
10. Шүлэглэлт номын сонгомол орчуулга. Дэлгэрсэн орчуулав. Үндэстний хэвлэлийн хороо. 1985.
11. Шүлэглэлт ном. Хятад хэлнээс орчуулсан Базаррагчаа.Ц. УБ., 1999.
12. Явуухулан.Б, Чимид.Ч. Ли Бо. Шүлгүүд. УБ., 1960.
13. Буяны залбирал. Хятад хэлнээс орчуулсан Базаррагчаа.Ц. УБ.,2006
14. Хүрэлбаатар.Л. Судар шаштирын билиг. УБ., 2002.
15. Ши Найань, Луо Гуанжун. Шүй хугийн бүрэн үлгэр. 施耐庵, 罗贯中 著。水浒传 全传. Чанша. 2004.